



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/484

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтууд болон “Централ секюритиз УЦК” ХХК-ийн 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 26/25 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүн “Централ секюритиз УЦК” ХХК (Б.Мөнгөншагай)-д Үнэт цаасны арилжаанд оролцох FIX эрх шинээр олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан ажилтанд Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1525031010